



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.eit.mn

2024.06.03 № 01/979

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД**

Тус компаниас 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зарласан ЭТТХК/20240102305 дугаартай "Toyota маркийн автомашины сэлбэг" нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг тендерт оролцогчоос гаргасны дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж, 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/855 дугаартай "Тендерийн баримт бичиг хянасан тухай" ирүүлсэн албан бичгийн дагуу тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

ТШЗ-ны холбогдох заалт	В. ТЕНДЕР БЭЛТГЭХ		
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцтай		
	Багцын дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Багцын дугаар
	Багц 1.	Toyota, Lexus маркийн тээврийн хэрэгслийн төлөвлөгөөт үйлчилгээний материал	ЭТТХК/20240102305-1
	Багц 2.	Toyota, Lexus маркийн тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги	ЭТТХК/20240102305-2
ТШЗ 1.3	Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: "Тийм" Багц 1: Toyota, Lexus маркийн тээврийн хэрэгслийн төлөвлөгөөт үйлчилгээний материал Дотоодод үйлдвэрлэсэн болохыг нотлох баримт бичгийг ирүүлнэ.		
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 1,006,179,937 (Нэг тэрбум, зургаан сая, нэг зуун далан есөн мянга, есөн зуун гучин долоо) төгрөг		
	Багцын дугаар	Төсөвт өртөг /төгрөг/	Төсөвт өртөг /үсгээр/
	Багц 1.	156,322,960	Нэг зуун тавин зургаан сая, гурван зуун хорин хоёр мянга, есөн зуун жар
	Багц 2.	849,856,977	Найман зуун дөчин есөн сая, найман зуун тавин зургаан мянга, есөн зуун далан долоо
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: "Шаардана"		
	Багцын дугаар	Баталгааны дүн /Мөнгөн дүнгээр/	Баталгааны дүн /Үсгээр/
	Багц 1.	156,322,960	781,615
	Багц 2.	849,856,977	4,249,285
Хүчинтэй байх хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.			
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ			
ТШЗ 24.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй.		
ТШЗ 26.1.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна.		

1124041757

Огноо: 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут Тендер нээх газрын хаяг: "Эрдэнэс Таван толгой" ХК, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын-8, Финанс төв, 5-р давхар, 502тоот, Улаанбаатар хот-15160, Монгол Улс
--

Хавсралтаар өөрчлөлт орсон тендерийн баримт бичгийг хүргүүлж байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт:..... хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ